

ЭДИЙН ЗАСГИЙН ТУСГАЙ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуульд эдийн засгийг хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, төсөв, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх төрийн чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Улсын Их Хурлын 1995 оны 87 дугаар тогтоолоор “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”-ыг баталж, экспортын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, орчин үеийн технологи, худалдаа, удирдлагын арга барилыг нэвтрүүлэх, ажлын байр болон валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор чөлөөт бүс хөгжүүлэх бодлогын үндсийг тавьсан.

Чөлөөт бүсийн тухай хууль 2015 онд батлагдсанаас хойш Монгол Улсын хөгжлийн бодлого, эдийн засгийн бүтэц, хөрөнгө оруулалтын орчин болон олон улсын худалдаа, технологийн чиг хандлагад томоохон өөрчлөлт гарсан. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт чөлөөт болон тусгай бүс, боомт, логистик, аж үйлдвэр, өндөр технологи, инноваци, аялал жуулчлал, санхүүгийн үйлчилгээ, мэдээллийн технологид тулгуурласан төрөлжсөн хөгжлийн төвүүдийг бий болгох зорилтыг тусгасан.

Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ болон практик нөхцөл байдлын судалгаагаар одоогийн эрх зүйн зохицуулалт нь дээрх бодлогын зорилтыг бүрэн хангахад хүрэлцэхгүй, эдийн засгийн тусгай бүсийг олон улсын хөгжлийн чиг хандлага болон Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төрөлжүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага

Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Чөлөөт бүсийн тухай болон бусад хууль тогтоомжид “чөлөөт бүс”, “эдийн засгийн чөлөөт бүс”, “эдийн засгийн тусгай бүс”, “тусгай бүс”, “худалдааны чөлөөт бүс”, “олон улсын санхүүгийн төв” зэрэг нэр томъёог зэрэгцүүлэн хэрэглэж байгаа боловч тэдгээрийн эрх зүйн ялгаа, харилцан уялдаа тодорхой бус байгаагаас хууль хэрэглээний эргэлзээ үүсэх нөхцөл бүрдсэн.

Мөн Чөлөөт бүсийн тухай хууль нь худалдаа, үйлдвэрлэл, технологи, логистик, аялал жуулчлал болон бусад өөр өөр зорилго бүхий бүсийг нэг нийтлэг зохицуулалтаар хамруулсан тул бүс бүрийн байршил, эдийн засгийн чиглэл, хөрөнгө оруулалтын хэрэгцээнд нийцсэн ялгамжтай бодлого дутмаг байна.

Бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх асуудлыг шийдвэрлэхэд тавигдах техник, эдийн засаг, дэд бүтэц, байгаль орчин болон эдийн засгийн үр ашгийн шалгуур хангалттай тодорхой бус байгаа нь бодит судалгаа, тооцоонд тулгуурлаагүй бүс байгуулах, улмаар тухайн бүс зорилгоо хангахгүй, эдийн засгийн үр ашиггүй ажиллах эрсдэлийг бий болгож байна.

Татвар, гааль, газар ашиглалт, ажиллах хүчтэй холбоотой одоогийн хөнгөлөлт, тусгай нөхцөл нь хөрөнгө оруулалтын хэмжээ, бий болгосон ажлын байр, экспортын гүйцэтгэл, технологийн түвшин болон салбарын онцлогтой хангалттай уялдаагүй тул өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн томоохон хөрөнгө оруулалтыг татах үр дүнд суурилсан урамшууллын механизм болж чадаагүй.

Түүнчлэн газар ашиглах хугацаа, эрхийн сунгалт, хөрөнгө оруулалтын хамгаалалт, кадастр, үнэлгээ, ил тод байдалтай холбоотой зохицуулалт хөрөнгө оруулагчийн урт хугацааны хэрэгцээг бүрэн хангаж чадахгүйн зэрэгцээ нэг цонхны үйлчилгээ хуульд тусгагдсан хэдий ч ямар төрлийн үйлчилгээг аль байгууллага ямар хугацаанд үзүүлэх, байгууллагууд мэдээллээ хэрхэн солилцох зохицуулалт тодорхой бус байгаагаас уг үйлчилгээ практикт бүрэн хэрэгжих боломжгүй байна.

Бүсийн бүртгэл, зөвшөөрөл, газар, татвар, гааль болон бусад мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн сан бүрдээгүй, төрийн мэдээллийн бусад сантай холбогдох зохицуулалт болон дата менежмент, мэдээллийн аюулгүй байдлыг хариуцах этгээдийн эрх хэмжээ тодорхой бус байна.

Түүнчлэн бүсийн удирдлага шийдвэр гаргахдаа олон шат дамжлагатай, мөн байгууллагуудын чиг үүрэг давхардсан, бүсийн захиргааны эрх хэмжээ болон санхүүгийн бие даасан байдал хангалтгүй байгаагаас хөрөнгө оруулагчийн хэрэгцээнд шуурхай хариу өгөх, зах зээлийн өөрчлөлтөд нийцүүлэн бүсийг удирдах боломж хязгаарлагдмал байдаг.

Оюуны өмч, худалдааны нууцыг хамгаалах, гаалийн хилээр оюуны өмчийн эрх зөрчсөн бараа нэвтрэхээс сэргийлэх, хөрөнгө оруулагч болон бүсийн оролцогчдын хооронд үүсэх иргэний, арилжааны, захиргааны, татварын болон хөрөнгө оруулалтын маргааныг шуурхай, ойлгомжтой журмаар шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Иймд Чөлөөт бүсийн тухай хуулийг эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн цогц бодлогыг шинэчлэн найруулж, хуулийн нэрийг “Эдийн засгийн тусгай бүсийн тухай хууль” болгон өөрчлөхөөр хуулийн төслийг боловсруулсан болно.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ач холбогдол

Хуулийн төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн тусгай бүс байгуулах, хөгжүүлэх эрх зүйн үндсийг шинэчлэн тогтоож, бүсийг эдийн засгийн чиг үүрэг, байршил болон хөгжлийн онцлогоор төрөлжүүлэх, хөрөнгө оруулалт татах, экспортын үйлдвэрлэл болон импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, инноваци, технологийн дамжуулалтыг дэмжих, бүс нутгийн хөгжлийг хурдасгах, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод болгоход оршино.

Мөн хөрөнгө оруулагчдад урт хугацаанд тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой эрх зүйн орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын бодит үр дүнтэй уялдсан хөнгөлөлт, татварын тусгай дэглэм тогтоох, газар ашиглалтын эрхийн баталгааг сайжруулах, оюуны өмчийг хамгаалах, маргаан шийдвэрлэх үр нөлөөтэй механизм бүрдүүлэхэд хуулийн төсөл чиглэсэн.

Гурав. Хуулийн төсөлд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалт

1. Эдийн засгийн тусгай бүсийн ойлголт, ангиллыг шинэчлэн тодорхойлсон

Хуулийн төсөлд “эдийн засгийн тусгай бүс”-ийг ерөнхий буюу суурь ойлголт болгон тодорхойлж, одоогийн “чөлөөт бүс”-ийг уг ерөнхий тогтолцооны нэг хэлбэр болгон системчилсэн.

Ингэснээр өөр өөр зорилго, үйл ажиллагаатай бүсийг нэг зохицуулалтад хамруулахын оронд тухайн бүсийн эдийн засгийн үндсэн чиг үүрэг, байршил, дэд бүтцийн онцлогтой уялдуулан худалдаа, экспортын зориулалт, аж үйлдвэр, технологи-инновац, логистик-тээвэр, болон аялал жуулчлалын тусгай бүсээр төрөлжүүлэн хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Хилийн боомт, худалдааны урсгалд суурилсан бүс, экспортын үйлдвэрлэлд чиглэсэн бүс, нийтлэг дэд бүтэц бүхий аж үйлдвэрийн бүс, судалгаа, инноваци, дижитал эдийн засагт тулгуурласан технологийн бүс, тээврийн зангилаанд түшиглэсэн логистикийн бүс тус бүрд тохирсон эрх зүйн орчин бүрдүүлэх боломж энэхүү ангиллаар бий болно.

2. Бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах зохицуулалтыг тодорхой болгосон

Эдийн засгийн тусгай бүс байгуулах шийдвэрийг тухайн газар нутгийн бодит хэрэгцээ, хөгжлийн бодлого, техник, эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, байгаль орчны үнэлгээ, дэд бүтцийн бэлэн байдал зэрэг бодит шалгуурт үндэслэхээр зохицуулсан.

Бүсийн байршил, хилийн цэсийг өөрчлөх болон бүсийг татан буулгах үндэслэл, шийдвэр гаргах журмыг хуульчилж, анх байгуулагдсан зорилгоо хангахгүй болсон, эдийн засгийн үр ашиггүй болсон зэрэг нөхцөлийг татан буулгах үндэслэлд хамааруулахаар тусгасан.

Мөн асуудлын цар хүрээ, эдийн засаг, нийгмийн нөлөөллөөс шалтгаалан бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэрийг зохих түвшинд гаргах эрх хэмжээний ялгааг тодорхой болгосон.

3. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн харилцааг нарийвчлан зохицуулсан

Хөрөнгө оруулагч бүрд ижил нөхцөлөөр хөнгөлөлт үзүүлэх аргаас татгалзаж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бий болгосон ажлын байр, экспортын гүйцэтгэл, технологийн түвшин, салбарын онцлог болон тухайн бүсийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан ялгамжтай дэглэм хэрэглэх эрх зүйн үндсийг бий болгосон.

Үүнд гааль, татвар, бүртгэл, ажиллах хүч, виз, газар ашиглалт болон бусад зохицуулалтын хөнгөлөлтийг тухайн хөрөнгө оруулалтын бодит эдийн засгийн үр өгөөжтэй уялдуулах нөхцөлийг тусгасан.

Хөрөнгө оруулагчийн хүлээсэн үүрэг, бүтээн байгуулалтын хугацаа, хөрөнгө оруулалт болон ажлын байрны доод шаардлагын хэрэгжилттэй хөнгөлөлтийг холбосноор газрыг болон бусад давуу эрхийг ашиглалгүй удаан хадгалах эрсдэлийг бууруулахад чиглэсэн.

4. Газрын харилцааны тусгай дэглэмийг боловсронгуй болгосон

Эдийн засгийн тусгай бүс дэх үйлдвэрлэл, технологи, дэд бүтцийн хөрөнгө оруулалт урт хугацаанд хэрэгждэг онцлогийг харгалзан хөрөнгө оруулагчид газар ашиглах эрхийг тусгай бүсийн төрлөөс нь хамааран уян хатан байх зохицуулалтыг тусгасан.

Газрын эрхийг баталгаажуулах тусгай бүсийн газрын гэрчилгээний тогтолцоо, газрын кадастрын цахим бүртгэл, газар ашиглалтын гэрээ болон мэдээллийн ил тод байдлыг сайжруулах механизмыг нэвтрүүлэхээр тусгасан.

Газрын үнэлгээнд зах зээлийн харьцуулалтын, орлогын хөрвүүлэлтийн болон зардлын арга зэрэг зах зээлийн зарчимд суурилсан үнэлгээний аргачлалыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэхээр зохицуулсан.

5. Нэг цонхны төрийн үйлчилгээний тогтолцоог бодитой хэрэгжүүлэхээр зохицуулсан

Эдийн засгийн тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх хөрөнгө оруулагч зөвшөөрөл, бүртгэл, татвар, гааль, газар, барилга, хөдөлмөрийн зэрэг төрийн үйлчилгээг олон байгууллагаар тус тус дамжин авах бус, бүсийн захиргаагаар дамжуулан нэг цонхны зарчмаар авах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Үйлчилгээ тус бүрийг аль байгууллага, ямар хугацаанд шийдвэрлэх, мэдээллийг цахимаар хэрхэн солилцох, бүсийн захиргаа болон төрийн бусад байгууллагын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгосноор төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулахад чиглэсэн.

6. Мэдээллийн нэгдсэн сан бий болгохоор зохицуулсан

Эдийн засгийн тусгай бүсийн бүртгэл, зөвшөөрөл, газар, гааль, татвар болон бусад холбогдох мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн нэгдсэн санг хуульчилж, төрийн бусад мэдээллийн системтэй харилцан мэдээлэл солилцох эрх зүйн үндсийг бий болгосон.

Мэдээллийн нэгдсэн санг зөвхөн захиргааны дотоод хэрэглээний систем бус, хуульд заасан хүрээнд олон нийтэд нээлттэй мэдээллийн эх сурвалж байхаар зохицуулж, мэдээллийн үнэн зөв байдал, нэвтрэх эрх, хувийн мэдээллийн хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал болон зөрчил гаргасан этгээдийн хариуцлагыг тодорхой болгосон.

7. Эдийн засгийн тусгай бүсийн удирдлагын тогтолцоог шинэчилсэн

Эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн бодлого, тогтвортой хөгжил болон байгууллага хоорондын зохицуулалтыг нэгдсэн байдлаар хангах Үндэсний зөвлөлийн тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан.

Бүсийн өдөр тутмын удирдлагыг зах зээлийн хэрэгцээнд шуурхай нийцүүлэх зорилгоор бүсийн захиргааны эрх хэмжээ, бие даасан байдал, санхүүжилт болон гүйцэтгэлийн шалгуурыг тодорхой болгож, шаардлагатай тохиолдолд компанийн оролцоонд суурилсан удирдлагын загвар ашиглах эрх зүйн боломжийг бүрдүүлсэн.

8. Оюуны өмчийн хамгаалалтын тусгай зохицуулалтыг бий болгосон

Технологи, инноваци, судалгаа, өндөр нэмүү өртөгтэй үйлдвэрлэлийг эдийн засгийн тусгай бүсэд татах нөхцөл бүрдүүлэх зорилгоор патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, худалдааны нууц болон бусад оюуны өмчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгайлан тусгасан.

Оюуны өмчийн эрх зөрчсөн бараанд гаалийн хяналт хэрэгжүүлэх, холбогдох байгууллагууд мэдээлэл солилцох, гэрээний харилцаанд оюуны өмчийн хамгаалалтын шаардлагыг тусгах боломжийг тодорхой болгосон.

9. Маргаан шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгосон

Эдийн засгийн тусгай бүсийн оролцогчдын хооронд үүсэх иргэний, арилжааны, захиргааны, татварын болон хөрөнгө оруулалтын маргааны харьяалал, шийдвэрлэх механизмыг илүү тодорхой болгохоор хуулийн төсөлд зохицуулсан.

Арбитр, эвлэрүүлэн зуучлал болон шүүхийн тогтолцоог зохистой хослуулах, маргааныг шүүхийн өмнөх шатанд эвлэрүүлэн зуучлах зэрэг боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Тусгай бүсийн удирдлагад төрийн өмчит компани оролцсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээнд талууд сайн дурын үндсэн дээр олон улсын арбитр сонгох, арбитрын шийдвэрийг Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хүлээн зөвшөөрч, биелүүлэх эрх зүйн баталгааг тодорхой болгох зохицуулалтыг мөн тусгасан.

Дөрөв. Хуулийн төслийн бүтэц, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь эдийн засгийн тусгай бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, бүсийн оролцогчид үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулалт хийх, газар ашиглах, зөвшөөрөл, бүртгэл, татвар, гааль, хөдөлмөр эрхлэлт, дэд бүтэц, төрийн үйлчилгээ, мэдээллийн сан, оюуны өмч, удирдлага болон маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Хуулийн төсөлд нийтлэг үндэслэл, тусгай бүсийн төрөл, бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, бүсэд эрхлэх үйл ажиллагаа, тусгай дэглэм, татварын чөлөөлөлт, хөнгөлөлт, оюуны өмчийн хамгаалалт, газрын харилцаа, дэд бүтэц, нэг цонхны үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн сан, удирдлага, харуул хамгаалалт, аюулгүй байдал, маргаан шийдвэрлэх болон шилжилтийн зохицуулалтыг тусгасан.

Хуулийн үйлчлэлд дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, хуулийн этгээд, иргэн, төрийн болон орон нутгийн байгууллага, бүсийн захиргаа, төрийн өмчит компани болон бусад хувийн хэвшлийн оролцогч хамаарна.

Тав. Хуулийн төсөл батлагдсанаар гарах үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн тусгай бүсийг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төрөлжүүлэн хөгжүүлэх эрх зүйн цогц орчин бүрдэнэ.

Хөрөнгө оруулалтын хэмжээ болон бодит үр дүнтэй уялдсан тусгай дэглэм бий болсноор өндөр технологи, инноваци, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл болон экспортын чиглэлийн томоохон хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэх, ажлын байр болон орон нутгийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

Мөн дотоодод үйлдвэрлэдэггүй, эсхүл дотоодын үйлдвэрлэл нь хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бараа, бүтээгдэхүүнийг тусгай бүсэд үйлдвэрлэх, дотоодын зах зээлийг тэргүүн ээлжид тогтвортой, өрсөлдөхүйц нөхцөлөөр хангах үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Төрийн үйлчилгээг нэг цонхны болон цахим хэлбэрт шилжүүлж, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог хуульчилснаар үйлчилгээний шат дамжлага, хугацаа буурч, үйл ажиллагааны ил тод байдал сайжрах боломжтой байна.

Газрын эрх, хөрөнгө оруулалтын хамгаалалт, оюуны өмч болон маргаан шийдвэрлэх тогтолцоог тодорхой болгосноор хөрөнгө оруулагчийн эрх зүйн орчны тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байдал нэмэгдэх ач холбогдолтой.

Нөгөө талаас одоогийн чөлөөт бүсүүдийг шинэ тогтолцоонд шилжүүлэх, өмнө олгосон газар, зөвшөөрөл, татвар, гаалийн нөхцөлийг шинэ зохицуулалттай нийцүүлэх, удирдлагын шинэ бүтэц, мэдээллийн нэгдсэн сан болон нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой шилжилтийн зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлага үүснэ.

Иймд одоо байгаа эрх, зөвшөөрөл, гэрээний үргэлжлэх нөхцөл, шинэ ангилалд шилжүүлэх журам, татвар болон бусад хөнгөлөлтөд тавих шалгуур, хугацаа, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг хуулийн төсөл болон түүнийг дагаж мөрдөх журмын зохицуулалтаар тодорхойлсон.

Зургаа. Бусад хууль тогтоомжтой уялдуулах асуудал

Хуулийн төсөлтэй холбогдуулан эдийн засгийн тусгай бүсийн нэр томьёо, удирдлага, татвар, гааль, газар, хөрөнгө оруулалт, зөвшөөрөл, бүртгэл, хөдөлмөр, мэдээлэл, оюуны өмч болон маргаан шийдвэрлэхтэй холбоотой хууль тогтоомжийн уялдааг хангах шаардлага үүссэн.

Энэ хүрээнд Засгийн газрын тухай, хөгжлийн бодлого, төлөвлөлт болон бүсчилсэн хөгжлийн удирдлага, төсөв, төрийн болон орон нутгийн өмч, төр, хувийн хэвшлийн

түншлэл, зөвшөөрөл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, газар, кадастр, хот байгуулалт, барилга, гааль, татвар, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлт, хувийн мэдээлэл, нийтийн мэдээлэл, кибер аюулгүй байдал, цахим гарын үсэг, оюуны өмч, арбитр, эвлэрүүлэн зуучлал, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомжид шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулсан.

Ингэснээр эдийн засгийн тусгай бүсийг хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, экспорт, технологи, инноваци, логистик болон бүсчилсэн хөгжлийг дэмжих эдийн засгийн бодлогын бие даасан хэрэгсэл болгон хөгжүүлэх, хөрөнгө оруулагчид тогтвортой, ил тод, шуурхай эрх зүйн орчин бүрдүүлэх нөхцөл бий болно.

- - - оОо - - -